



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/40

Шивээговь сум

Газар зүйн нэрийн салбар зөвлөл  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлиг, Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	(Газрын даамал)
Гишүүд:	(1 дүгээр багийн Засаг дарга)
	(2 дугаар багийн Засаг дарга)
	(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)
	(Байгаль орчны мэргэжилтэн)
	(Улсын бүртгэгч)
	(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
	(Мал эмнэлгийн тасаг)

2. Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хийгдэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг сумын хэмжээнд хийх ажлыг зохион байгуулах, газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, шинээр өгөх, өөрчлөх газар зүйн нэрийн саналыг хэлэлцэж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн дээд шатны байгуулагад холбогдох тайлан, мэдээг хүргүүлж ажиллахыг салбар зөвлөлийн дарга Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212 111